



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/60

Улаан-Уул

Өндөржүүлсэн бэлэн байдлын
зэрэг шилжүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, аймгийн Засаг даргын А/295 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус суманд Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль болохтой холбогдуулан 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 12:00 цагаас 05 дугаар сарын 26-ны өдрийн 12:00 цаг хүртэл хугацаанд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2.Өндөржүүлсэн бэлэн байдал шилжсэнтэй холбогдуулан дараахь ажил арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад тус тус үүрэг болгосугай.

2.1.Сумын онцгой комиссын штаб, мэргэжлийн анги, албадын бие бүрэлдэхүүнийг гамшгийн үеийн бэлэн байдлыг хангуулахыг мэргэжлийн анги, штабын дарга нарт,

2.2.Шаардагдах хөрөнгө санхүүгийн тооцооллыг гарган холбогдох шийдвэр гаргуулахыг Тамгын газрын дарга болон Санхүү албаны дарга нарт,

2.3.Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуульд иргэний үүргээ биелүүлэн идэвхтэй оролцохыг сумын нийт ард, иргэдэд,

2.4.Архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглож, архи, согтууруулах ундааг тоолж лацдахыг хэсгийн төлөөлөгч, Цагдаагийн дэслэгч (Д.Насанжаргал)-д

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Баттогтох)-д даалгасугай.

ДАРГА  Т.ЭРДЭНЭБАТ



642201099